



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 1188

Шивээговь сум

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, 29.1.6.л, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 2020 оны 238 дугаар тогтоол, Журам батлах тухай 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 08, 20, 21 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/64 дүгээр захирамж, сумын Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд үйл ажиллагааг нь зогсоосон аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, үйлчилгээний газрууд, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс нээж, ердийн цагийн хуваарийн горимд шилжүүлсүгэй.

2. Ердийн горимд шилжиж үйл ажиллагаа нь нээгдсэнтэй холбогдуулан “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын 2, 3 дугаар заалтад заагдсан “Бэлтгэл ажлын үед авах арга хэмжээ”, “Зохион байгуулалтын арга хэмжээ”-ний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, үйлчилгээний газрууд, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

3. Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, үйлчилгээний газруудын үйл ажиллагаа эхлэхийн өмнөх бэлтгэл ажил, арга хэмжээний явц,


гүйцэтгэл, үйл ажиллагаа эхэлсэний дараах халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох хуулийн дагуу үйл ажиллагааг зогсоох тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч /Ш.Буяннэмэх/, Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Сувданцэцэг/ нарт, Нийслэл болон голомтын бүс нутгаас ирж байгаа иргэдийн гар утсанд “CLIX GPS” систем суулгаж, хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын гишүүн /Э.Баярмагнай/, /С.Лхагвадорж/, Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа /Г.Ууганбаатар/ нарт, Улаанбаатар хотоос ирсэн иргэдийг гэр бүлийн гишүүдийн хамт гэрийн ажиглалтанд 7 хоног тусгаарлаж халдвар хамгааллын дэглэм сахиулахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Сувданцэцэг/, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/, 1, 2 дугаар багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Төрийн албан хаагчдыг ажлын байранд 50/50 харьцаатай ажиллуулж, 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцгийг гэрээсээ ажиллах нөхцөлийг хангаж цахимаар ажиллуулахыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5. 22 дугаар зөрлөгийн гарамын хяналтын постонд тусгай чиг үүргийн байгууллага хяналт тавихаас гадна бусад аж ахуйн нэгж, байгууллагууд хуваарийн дагуу 24 цагаар үүрэг гүйцэтгэх, Хөдөлгөөнт эргүүлийг зохион байгуулахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ